



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОР С.МАГНАЙСҮРЭН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2025.08.26 № 33

Эдийн засгийн хараат бус
хяналтын хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дугаар заалтад Улсын Их Хурал нь “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж заасны дагуу Үндэсний аудитын газар нь төрийн санхүү, төсөв, нийтийн өмчийг зохистой төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулахад тавих хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх бүрэн эрхтэй байгууллага билээ. Үндсэн хуулиар хүлээсэн энэхүү чиг үүргийн хэрэгжилт ямар түвшинд байна? Төрийн аудит хийх чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд саад учруулж буй асуудал байгаа эсэх?

2.Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын жилийн төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар Үндэсний аудитын газраас жил бүр дүгнэлт гаргасаар ирсэн билээ. Танай байгууллагаас гаргадаг энэхүү дүгнэлт, саналын хэрэгжилт, түүний үр нөлөөний талаар хийсэн судалгаа бий эсэх; хэрэв дүгнэлт, саналын хэрэгжилт хангалттай бус бол үүний учир шалтгаан болон үр дагаврыг арилгах ямар арга хэмжээ авдаг вэ?

3.Улсын нэгдсэн төсөв дэх хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, худалдан авах ажиллагаа, гадаад зээл, тусламж, хандив, санхүүгийн дэмжлэгийн төлөвлөлт, гүйцэтгэл, ашиглалт, зарцуулалт, хэрэгжилт, тайлагнал дахь нийтлэг гол алдаа, дутагдлууд, тэдгээрийг дахин давтахгүй байх үүднээс хэрэгжүүлэх арга хэмжээний талаар зохих танилцуулга мэдээлэл өгнө үү.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан хугацаанд ирүүлнэ үү.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

С.ЭРДЭНЭБОЛД



2025000055